

**Улсын хилийн бүс, зурвас газарт харилцаа холбооны үйл ажиллагаа
явуулахад шаардагдах нөхцлүүд**

Хамрах хүрээ

1. Монгол Улсын хилийн бүс, зурвас газарт харилцаа холбооны шугам, сүлжээ байгуулахаар хайгуул хийх, түүний төслийг боловсруулах, барьж байгуулах, шугам, сүлжээний ашиглалт эрхлэх (урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ хийх болон гэмтлийг сэргээн засварлах), шугам сүлжээг устгах (задлан салгаж ашиглалтаас хасах) талаархи улсын нэгдсэн сүлжээний мэдээллийн санг үүсгэж түүний нэгдсэн бүртгэлийг хөтлөхөд энэхүү нөхцөл шаардлагын зорилго оршино.
2. Харилцаа холбооны шугам, сүлжээ нь Монгол Улсын хилийн бүс, зурвас газарт үргэлжилж байгаа бүх тохиолдолд /эсхүл Монгол Улсын хил давж хөрш орны сүлжээтэй холбогдох бол/ энэхүү нөхцөл, шаардлага үйлчилнэ.

I.Ерөнхий нөхцөл

3. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос (цаашид Зохицуулах Хороо гэх) олгосон тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж Монгол Улсын хилийн бүс, зурвас газарт харилцаа холбооны шугам, сүлжээ байгуулахаар төслийн хайгуул хийх, төслийг боловсруулах, барьж байгуулах, ашиглалтыг эрхлэх (урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээ хийх болон гэмтлийг сэргээн засварлах) шугам сүлжээг задлан салгаж ашиглалтаас хасах ажлыг хийж гүйцэтгэнэ.
4. Монгол Улсын хилийн бүс, зурвас газарт дээрх зорилгоор үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээр, хилийн болон хил орчмын дэглэмийг хүндэтгэн сахих үүрэг хүлээнэ.
5. Зохицуулах хороо нь Хил хамгаалах байгууллага, зам, тээвэр, байгаль орчин, технологи, цөмийн хяналт, батлан хамгаалах, аюулгүй байдал, гаалийн болон байгаль ашиглалтын эрх бүхий байгууллагуудтай зөвшилцсөнийг үндэслэж ирүүлсэн хүсэлтийг хянан **нэгдсэн сүлжээний мэдээллийн санд** бүртгэнэ. Бүртгэлд оруулахаас татгалзсан хүсэлтийн бүртгэлийг мөн адил хийж шалтгааныг тодорхой дурдана.
6. Хүсэлт гаргагч нь Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Харилцаа холбооны тухай хуулинд заасан бичиг баримтуудаас гадна дараахи мэдээллийг дэлгэрэнгүй ирүүлнэ. Үүнд:
 - үйл ажиллагааны дараахи төрлийн алин болох (төслийн хайгуул хийж төслийг боловсруулах, сүлжээг барьж байгуулах, түүний ашиглалтыг эрхлэх (урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээ хийх болон гэмтлийг

сэргээн засварлах), шугам сүлжээг задлан салгаж ашиглалтаас хасах)-ыг дурдана.

- үйл ажиллагааны зорилго;
 - эхлэх ба дуусах хугацаа;
 - авто болон төмөр замын эргэлт, нефть болон хий дамжуулах хоолой, бусад технологийн объектийн болон хилийн шалган нэвтрүүлэх боомтын тусгай хэрэгцээний газарт ажиллахыг зөвшөөрснийг баталсан бичиг баримтууд;
 - ажлын үед ослоос сэргийлэх болон ослыг арилгах ажлын жагсаалт;
 - ажил хийж гүйцэтгэхэд мөрдөгдөх стандартууд
7. Харилцаа холбооны шугам, сүлжээний төслийн хайгуул болон төслийг боловсруулах, харилцаа холбооны шугам, сүлжээг барьж байгуулах, харилцаа холбооны шугам, сүлжээний ашиглалт эрхлэх, түүнийг задлан салгаж ашиглалтаас хасахдаа дор дурдсан шаардлагыг хангаж ажиллана.
- Хилийн бүс, зурваст явуулж буй үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчин болон тэнд оршин суугаа хүн амд хор нөлөө учруулахгүй байх, бүхэлдээ Монгол Улсын экологийн болон бусад аюулгүй байдалд нөлөө үзүүлэхгүй байх
 - Хилийн бүс, зурваст явуулж буй үйл ажиллагаа нь Хил хамгаалах байгууллагын тусгай хэрэглээний холбоо, мэдээллийн сүлжээ, дамжин нисч буй агаарын нислэгт нөлөөлсөн дуу шуугиан үүсгэхгүй байх, мөн урд нь байгуулсан инженерийн бусад байгууламжийн засвар, ашиглалт үйлчилгээ, эдийн засаг санхүүгийн үйл ажиллагаанд саад, хохирол учруулахгүй байх
 - бүхэлдээ Улсын нэгдсэн сүлжээний аюулгүй ажиллагаа болон тогтвортой ажиллагаанд нөлөөлөхгүй байх
 - Хилийн бүс, зурваст харилцаа холбооны шугам, сүлжээ байгуулахаар төслийн хайгуул хийх, төслийг боловсруулах, барьж байгуулахдаа холбогдох стандартын дагуу хийгдсэн ажлын зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.

II. Хилийн бүс, зурвас газарт харилцаа холбооны шугам, сүлжээ байгуулах төслийн хайгуул хийх, төслийг боловсруулах

1. Ерөнхий нөхцлийн 5 болон 6-д зааснаас гадна хайгуул явуулах нутгийн газар зүйн солбилцлууд болон харилцаа холбооны шугам байгуулахаар урьдчилан төлөвлөж буй трассын талаархи мэдээлэл.
2. Хэрэв тухайн төсөл нь өндөр хүчний цахилгаан дамжуулах шугам, авто болон төмөр зам, нефть, хий, хүнс дамжуулах бусад технологийн зориулалттай объектууд болон хилийн шалган нэвтрүүлэх боомтыг хөгжүүлэх төлөвлөгөөний нэг хэсэг болох бол нэгдсэн төслийн тухайн хэсэгт хамрагдах шинжээчийн дүгнэлтийг тус тус ирүүлнэ.
3. Хэрэв харилцаа холбооны шугам Улсын хилийг огтлон гарах бол тухайн цэгийн газар зүйн солбилцлуудыг Харилцаа холбооны зохицуулах хороо

болон Хил хамгаалах байгууллагатай урьдчилан зөвшилцсөний дараа хөрш улсын харилцаа холбооны байгууллагуудтай хэлцэлийг хийнэ.

4. Төслийн баримт бичгийг боловсруулахдаа Хил хамгаалах байгууллага болон орон нутгийн засаг, захиргаатай дараахи асуудлаар зөвшилцөнө. Үүнд:

- газар зүйн солбилцол бүхий харилцаа холбооны шугамын трассын зураг;
- Харилцаа холбооны шугамын трассын дамжин өнгөрч буй газрууд;
- Хилийн зурваст хөрш Улсын сүлжээтэй харилцан холбогдох цэгийн газар зүйн солбилцол болон холболт хийх дэлгэрэнгүй схем, технологийн тэмдэглэгээ;

III. Хилийн бүс, зурвас газарт харилцаа холбооны шугам, сүлжээг барьж байгуулах

1. Харилцаа холбооны шугам, сүлжээг хилийн бүс, зурваст барьж байгуулах ажлыг бүртгэлжүүлэхэд :
 - ✓ тухайн сүлжээгээр бизнесийн үйл ажиллагаагаа явуулах үйлчлэгчийг болон сүлжээний ашиглалтыг гардан явуулах байгууллагын талаар тодорхой дурдана;
 - ✓ тухайн сүлжээ нь Улсын нэгдсэн сүлжээний нэг хэсэг бол нэгдсэн төслийн холбогдох хэсэг, бие даасан сүлжээ бол төслийн батлагдсан бүрэн төслийн хуулбарыг ирүүлэх бөгөөд зөвхөн төсөлд заагдсаж баталгаажсан трассаар сүлжээг байгуулна;
 - ✓ тухайн сүлжээний тархалтын схемийг сүлжээний эхний болон төгсгөлийн цэг болон эргэлтийн цэгийн газарзүйн солбилцлүүдийн хамт;
 - ✓ сүлжээ байгуулж эхлэх болон дуусах хугацааг тодорхой зааж тус тус ирүүлнэ.
2. Хэрэв сүлжээ байгуулж эхлэх болон дуусах хугацаанд өөрчлөлт оруулах энэ талаархи тайлбар болон хүсэлтээ Зохицуулах хороонд ирүүлнэ.
3. Сүлжээ болон объектийг ашиглалтанд хүлээн авах үед Хил хамгаалах байгууллагын төлөөлөл болон мэргэжлийн хяналтын байгууллага оролцсон хүлээн авах комисс ажиллан сүлжээ батлагдсан төслийн дагуу хийгдсэн эсэхийг шалгаж акт үйлдэнэ. Шаардлагатай тохиолдолд тухайн хилийн хэсгийг хариуцан хамгаалж буй хилийн тусгай ангиас оролцоно.
4. Хүлээн авах комисст үзүүлж буй баримт бичигт харилцаа холбооны шугам сүлжээг ашиглах байгууллагын боловсруулсан тухайн сүлжээний ашиглалтын дүрмийн төслийг ирүүлэх бөгөөд тухайн дүрмийн төсөлд доорхи зүйлүүдийг хамруулсан байна. Үүнд:
 - (1) Засвар, үйлчилгээний графикт ажлын хуваарь
 - (2) Осол гэмтлийг засах, сэргээх ажлын дараалал
 - (3) Ашиглалтын ажлын талаар мэдээлэх шаардлагатай байгууллагуудын нэрс зэрэг болно.
5. Ашиглалтын дүрмийг хүлээн авах комиссын актыг үндэслэн сүлжээг эзэмшигч болон ашиглалтыг явуулах талууд баталж хувийг Зохицуулах хороонд ирүүлнэ.

6. Харилцаа холбооны шугам сүлжээг сэргээн шинэчлэж засварлах, ашиглалтанд шилжүүлэхдээ шугам сүлжээг шинээр барьж байгуулахтай адилтган үзэж энэ хэсгийн заалтуудыг мөрдөж ажиллана.

IV. Хилийн бүс болон зурвас газарт барьж байгуулсан харилцаа холбооны шугам, сүлжээний ашиглалт

1. Сүлжээний ашиглалтыг батлагдсан дүрмийн дагуу явуулна.
2. Ашиглалтын байгууллага нь төлөвлөгөөт үзлэг үйлчилгээ, засварын ажлыг явуулах тухайгаа (ямар ажлыг ямар хугацаанд явуулах) ажил эхлэхээс 30 хоногийн өмнө холбогдох байгууллагуудад мэдэгдэнэ.
3. Холбогдох байгууллагууд нь ажил явуулахад байлцах өөрийн төлөөллийн нэр болон байх хугацааг /ирж чадахгүй бол мөн тэр тухайгаа/ ашиглалтын байгууллагад мэдэгдэнэ. Холбогдох байгууллагууд нь оролцож чадаагүй тохиолдолд ашиглалтын байгууллага нь ажил дууссан болон үзлэг, засварын ажлын үр дүнг заавал мэдэгдэнэ.
4. Осол үүсэх ихээхэн магадлалтай болон үүссэн үед ашиглалтын байгууллага нь холбогдох байгууллагад энэ талаар болон осол гэмтлийг арилгах ажиллагааныхаа талаар мэдэгдэнэ. Ашиглалтын байгууллага нь осол саатлыг арилгах үйл ажиллагаагаа холбогдох байгууллагын төлөөлөл хүрэлцэн ирэхийг хүлээлгүйгээр эхлэх эрхтэй ба сэргээх ажлын явц, үр дүн дууссан хугацааны талаар тэдэнтэй байнга холбогдон мэдээлж байна. Осол саатлыг арилгах ажил нь дүрэмд заагдсан дарааллын дагуу явагдана.
5. Дүрэмд (ашиглалтын байгууллагыг өөрчлөх тухай) ашиглалтын байгууллагын эсхүл, сүлжээний өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу өөрчлөлт оруулж болно. Хүсэлтэд өөрчлөлт оруулах болсон шалтгааныг тодорхой дурдана.
6. Ашиглалтын байгууллага өөрчлөгдөх тохиолдолд шинэчилсэн дүрмийг 30 хоногийн хугацаанд баталж Зохицуулах хороонд дүрмийн хуулбарыг ирүүлж, цаашид ашиглалтыг эрхлэн явуулах аж ахуйн нэгж албан ёсоор Хил хамгаалах байгууллагад мэдэгдэнэ.

V. Хилийн бүс болон зурвас газарт барьж байгуулсан харилцаа холбооны шугам, сүлжээг ашиглалтаас хасах (задлан салгах)

1. Ерөнхий нөхцлийн 6-д зааснаас гадна хийх гэж буй устгалын талаархи мэдээлэл болон устгалын ажлын графикийг Зохицуулах хороонд ирүүлнэ.
2. Хороо ажлын 21 хоногийн дотор устгах шийдвэр эсхүл графикийг өөрчлөх саналаа өгнө. Уг ажлыг гүйцэтгэсний дараа салгасан эд ангиуд болон хэрэглэж байсан багаж хэрэгслийг хилийн бүс, хилийн зурвас газраас ачиж зайлуулна.

-----ooOoo-----